

“Сайхан Монгол орон” болон Япон

ХАЯШИ ЁШИМАСА

Япон Улсын Гадаад хэргийн сайд

Хэнтий, Хангай, Саяны өндөр сайхан
нуруунууд
Хойд зүгийн чилэг болсон ой хөвч уулууд
Мэнэн, Шарга, Нотины өргөн их говиуд
Өмнө зүгийн танлай болсон элсэн манхан
далайнууд
Энэ бол миний төрсөн нутаг
Монголын сайхан орон
(Д.Нацагдоржийн
“Миний нутаг” шүлгээс)



Япон Улсын Гадаад хэргийн сайд Ё.Хаяшигийн зургийг Японы ГХЯ-наас авч ашиглав

Монгол түмний бахархал болсон их зохиолч Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлэгт магтан дуулсан Монголын сайхан оронд Япон Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн тэмдэглэлт ойн энэ баярт үед Япон Улсын Гадаад хэргийн сайдын хувиар айлчлал хийх болсондоо туйлын их баяртай байна.

● Япон Улс, Монгол Улс
“Стратегийн түнш”

Урьд өмнө нь Япон, Монгол улс ойр мэт боловч хол улс байсан. Өөр нийгмийн тогтол-

● Япон, Монгол хоёр улсад “Харилцан туслалцах үзэл санаа” бий

Ихэнх хүмүүсийн мэдэж байгаачлан Япон бол Монголын хувьд хамгийн том донор орон. Гэхдээ хоёр орны хамтын ажиллагаа зөвхөн нэг талт биш юм. Хоёр улсад “Харилцан тус-

нээлтээ хийсэн Чингис хаан олон улсын нисэх буудал нь Япон, Монголын хамтын ажиллагааны шинэ бэлгэ тэмдэг билээ. Тус нисэх буудлыг Японы иений хөнгөлөлттэй зээлээр барьж, менежментэд японы компани оролцож байна. Энэ удаа өөрийн биеэр анх удаа энэ нисэх буудлаар үйлчлүүлэх гэж байна. Мөн харилцаа холбооны салбарт ч нягт харилцаа гүнзгий тавигдсан байна.

Соёл, спортын салбарт монгол сүмо бөхчүүд өндөр амжилт гарган томоохон байр суурь эзэлж байна. Тэдний хоёр орны харилцан ойлголцол, найрсаг харилцаанд гүйцэтгэсэн үүрэг их бөгөөд зоримог дайчин дүр төрхөөрөө олон япон, монголчуудад эрч хүч өгч ирсэн хэмээн бодож байна.

● Япон ба Монголын томоохон ялгаа

Хоёр улс нийтлэг үнэт зүйлстэй хэдий ч томоохон ялгаа ч мөн бий. Япон бол далайгаар хүрээлэгдсэн бол Монгол бол далайд гарцгүй улс.

Энэ мэт онцлогтой бөгөөд хувь тавилан гэж ч хэлж болохуйц геополитикийн нөхцөл дунд 1990 оноос хойш ардчиллын замыг сонгон, өдрөөс өдөрт өөрчлөгдөн хувьсаж буй бүс нутаг, олон улсын нөхцөл байдал дунд эрх чөлөө, ардчилал, хүний эрх, эрх зүйт төр хэмээх үнэт зүйлсээ хамгаалан хадгалж Энхийг сахиулах ажиллагаа зэргээр дамжуулан олон улсын хамтын нийгэмлэгт хувь нэмрээ оруулан хүндтэй байр суурь эзэлж ирсэн Монголчууд Та бүхний мэргэн ухаан, хатан

өнөөгийн нөхцөл байдлыг нэг талаас хүчээр өөрчлөх оролдлого хийх зэрэг Ази болоод олон улсын дэг журмын үндсийг бүхэлд нь ганхуулах хурцадмал байдал үүсээд байна. Ийм нөхцөл байдлын дунд ч эрх зүйт төрд тулгуурласан чөлөөт, нээлттэй олон улсын дэг журмыг хадгалан бэхжүүлэх явдал урьд өмнөхөөс илүү чухал болоод байна.

Д.Нацагдоржийн “Миний нутаг” бол зөвхөн Монголын үзэсгэлэнт байгалийг магтан дуулсан шүлэг биш хэмээн бодож байна. Шүлгийн сүүлийн хагаст тэрбээр Монголын өнө эртний түүх болоод үндэсний өв уламжлал, хувьтай энэ орноо хамгаалан мандуулья хэмээх зориг шулуудсан тухайгаа дуулсан байдаг. Түүний энэхүү чин эрмэлзэл XXI зууны монголчуудад үе залгамжлан үлдсэн хэмээн бодож байна.

Япон Улс ирэх 50 жилд ч бахдан бахархмаар Монгол оронтой хамтдаа хөгжин дэвжих хүсэлтэй.

● Цаашдын Япон ба Монгол

Миний бие Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн хамт энэ жил тохиож буй Япон Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг өнөөг хүртэлх 50 жилээ эргэн харж, ирэх 50 жилийн суурь, анд нөхрийн барилдлага тогтоох жил болгохоор санал нэгдсэн билээ. Мөн хоёр орны Ерөнхий сайд нар энэ жилийг “Хүүхэд залуучуудын найрамдал, солилцооны жил” хэмээн зарлаж ирээдүй хойч

цоотой хоёр улс 1972 онд дипломат харилцаа тогтоосны дараа хүйтэн дайны улмаас элдэв хориг саад дор харилцаж байсан.

Тухайн үед Япон Улс 1977 онд буцалтгүй тусламжаар “Говь” ноолуурын үйлдвэр байгуулж Монголд үйлдвэрлэсэн ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чадавх, дэлхийн үнэлэмжийг нэмэгдүүлэх суурийг тавилцахад хувь нэмрээ оруулсан нь хоёр орны түүхийн нэг хуудсан тод бичигдэж үлдсэн.

1990 онд томоохон өөрчлөлт эхэлсэн. Монгол Улс энэ жил ардчилал, зах зээлийн эдийн засгийн замыг сонгосон бөгөөд Япон Улс энэхүү зоригтой алхмыг дэлхийн улс орнуудыг манлайлан дэмжсэн билээ. Түүнээс хойш хоёр орны харилцаа үсрэнгүй хөгжиж, өнөөдөр Япон Улс, Монгол Улс эрх чөлөө, ардчилал, эрх зүйт төр хэмээх нийтлэг үнэт зүйлс бүхий “Стратегийн түнш” болоод байна.

“Харилцаа тусламж” ба “Харилцаа тусламж” үзэл санаа” баттай оршдог. Монгол Улсын Засгийн газар болоод монголын ард түмэн Японд болсон 1995 оны Ханшин-Аважи, 2011 оны Зүүн Хойд бүс нутагт болсон хүчтэй газар хөдлөлтөд түргэн шуурхай тусламжийн гараа сунгасан билээ. Энэ нь урьд өмнө тохиож байгаагүй зовлон бэрхшээлд гэнэт нэрвэгдсэн япончуудад хэчнээн их дэм болсныг хэлж мэдэхгүй байна.

Хоёр орны хооронд өндөр дээд албаныхны харилцан айлчлал идэвхтэй явагдан улс төр, аюулгүй байдал зэрэг олон салбар дахь яриа хэлэлцээ, зөвлөгөөн, харилцаа тогтмолжиж байна. Мөн бүс нутаг, олон улсын тавцан дахь хоёр орны хамтын ажиллагаа жилээс жилд гүнзгийрэн хөгжиж байна.

Эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбар дахь хамтын ажиллагаа ч мөн адил тууштай өргөжин тэлж байна. Өнгөрсөн жилийн зун

Монголчууд та бүхний мэргэн ухаан, хагас зоригийг чин сэтгэлээсээ бахархан бахадмаар байна.

Геополитикийн нөхцөл байдлаараа огт өөр хоёр улс хэдий ч “Эрх чөлөө ба ардчиллын үзэл санаа” агуулсан анд нөхөр мөн “Туравдагч хөрш”-ийн хувиар Япон Улс цаашид ч Монгол Улстай хамтдаа байхыг хүсэж байна.

- **Олон улсын хамтын нийгэмлэг сорилттой тулгараад байна**

Өнөөдөр, олон улсын хамтын нийгэмлэг ихээхэн өөрчлөгдөн хувьсаж улам бүр ээдрээтэй болж байна. Одоо Украинд үүсээд байгаа нөхцөл байдалд ажиглагдаж байгаачлан өнөөг хүртэл мөрдөж ирсэн олон улсын хууль болон дүрэм журмын түүхэн замнал, хуримтлуулсан туршлагыг бүхэлд нь үгүйсгэсэн, олон улсын хуулийг илэрхий зөрчих,

лидцөөны жил хэмээн зарлаж ирээдүй хойч үеийг залгамжлах Япон, Монгол хүүхэд залуучуудын харилцааг гүнзгийрүүлэх хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулахаар мөн харилцан тохиролцлоо.

Ирэх 50 жил Япон, Монголын ард түмэн бие биеэ улам бүр таньж мэдэж, харилцан хүлээн зөвшөөрч, хоёр улс хүчээ нэгтгэн өөрийн улс, хоёр улс цаашлаад бүс нутаг болоод дэлхийн ирээдүйн төлөө юу хийж чадах вэ гэдэг талаар сайтар тунгаан бодож шинэ түүхийг бүтээнэ. Монгол Улсад хийж буй энэ удаагийн миний айлчлал үүнд түлхэц болоосой хэмээн хүсэж байна.

Эцэст нь, миний бие их зохиолч Д.Нацагдоржийн шүлэглэсэн “Монголын сайхан орон”-ыг өөрийн нүдээр харж, тэрхүү сайхан нутагт амьдран суугаа Чингис хааны үр садтай уулзан учирч, илэн далангүй ярилцах гэж байгаадаа жаргалтай байна.